



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/56

Баян-Өндөр сум

Үндэсний их баяр наадам, бүх нийтийн амралтын өдрүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалт, 109 дүгээр зүйлийн 109.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам" А/36, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Үндэсний их баяр наадмын үеэр эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах тухай" 02 албан даалгавар, аймгийн Засаг Даргын 2024 оны "Хариуцлагатай эргүүл, жижүүрийг ажиллуулах тухай" А/493 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд ажиллах Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих байцаагч нарын хуваарийг хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баяр наадмын өдрүүдээр хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хүний нөөцийн бэлэн байдлыг ханган, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй, хүндрэл чирэгдэлгүй шуурхай үзүүлэхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг мэдээлэх бүртгэх АМ-36", "Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33 маягт"-ын дагуу бүртгэл мэдээг эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хугацаанд нь хүргүүлж, эргэн мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн (Г.Итгэл)-д үүрэг болгосугай.

4. Хяналтад байгаа бага насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хавсарсан эмгэгтэй жирэмсэн эх, төрөх эхчүүд, хэвтрийн, хүнд өвчтөнийг баяр наадмын амралтын өдрүүдийн өмнө заавал үзэж, зөвлөгөө өгөх, баяр наадмын өдрүүдэд дээрх иргэдтэй цахимаар болон утсаар холбогдон биеийн байдалд тогтмол хяналт тавьж ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

5. Баяр наадмын үеийн хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд "Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 2024 оны 08-00-02/03 дугаар удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, хоол хүнсээр дамжих хордлого, халдвар, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс (Д.Жаргал)-д даалгасугай.

6. Хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдал, хоол, хүнсээр дамжих хордлого, халдвар, осол гэмтэл, үер усны аюул зэрэг болзошгүй эрсдэлээс сэргийлсэн видео шторк, контент, мэдээлэл, зөвлөмжийг бэлтгэн баяр наадмын өмнө болон баяр наадмын өдрүүдээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр, цахим хуудсаар түгээж ажиллахыг Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-д даалгасугай.

7.Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бодож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д болон байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

8.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ



**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ
ЖИЖҮҮРИЙН НЭРС, ХУВААРЬ, ЧИГ ҮҮРЭГ**

Д/д	Албан хаагчийн овог нэр	Албан тушаал	Жижүүр хийх өдөр	Харилцах утасны дугаар	Чиг үүрэг
1	А.Ганчимэг	Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа, олон нийт хариуцсан ахлах мэргэжилтэн	7 сарын 10	99189394	Жижүүрийн хугацаанд эмнэлгүүдээр эргэлт хийх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэх тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний багийн ахлагчид мэдэгдэж, хариу арга хэмжээ авах.
2	П.Отгонбилэг	Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	7 сарын 11	99058187	
3	О.Анхбаяр	Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн	7 сарын 12	94351290	
4	Д.Отгондэлгэр	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	7 сарын 13	99017763	
5	Ч.Мөнхзул	Эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтэн	7 сарын 14	99519087	
6	Б.Уртнасан	Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн	7 сарын 15	99950350	Жижүүрийн хугацаанд эмнэлгүүдээр эргэлт хийх, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэх тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний багийн ахалж, газрын даргад мэдэгдэж хариу арга хэмжээг авах. Жижүүрийн тайланг нэгтгэж, удирдлагад танилцуулах.
7	Г.Итгэл	Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн	7 сарын 10-наас 15-ны өдрүүдэд	99967763	Жижүүрийн хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээг Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаг хугацаанд хүргүүлэх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэх тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний багийн ахлагчид мэдэгдэж, хариу арга хэмжээ авах.

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 07 сарын 08 өдрийн 4/3
дугаар тушаалын хавсралт



**БАЯР НААДМЫН ҮЕИЙН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ
ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ АЛБАН ХААГЧИЙН НЭРС**

Д/д	Албан хаагчийн овог нэр	Албан тушаал	Хяналт хийх өдөр	Харилцах утасны дугаар	Хяналт тавих газар
1	Д.Жаргал	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч	7 сарын 9	99357868	Цэнгэлдэх хүрээлэн
2	Б.Будсүрэн	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7 сарын 9	99279278	
3	Ч.Мөнхзул	Эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтэн	7-р сарын 9	99519087	
4	Д.Лхагважав	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7 сарын 9	99559380	Морь барианы газар
5	Б.Солонго	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7 сарын 9	91113917	
6	Б.Солонго	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7-р сарын 10 18:00-00:00	91113917	Цэнгэлдэх хүрээлэн
7	Д.Лхагважав	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7-р сарын 11 18:00-01:00	99559380	

**ГЭДЭСНИЙ ХАЛДВАР, ХООЛНЫ ХОРДЛОГО ГАРСАН ТОХИОЛДОЛД ДУУДАГДАЖ
АЖИЛЛАХ УЛСЫН БАЙЦААГЧИЙН НЭРС**

Д/д	Албан хаагчийн овог нэр	Албан тушаал	Дуудагдан ажиллах өдөр	Харилцах утасны дугаар
1	Б.Солонго	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7-р сарын 10	91113917
2	Д.Лхагважав	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7-р сарын 11	99559380
3	Д.Жаргал	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч	7-р сарын 12	99357868
4	Б.Будсүрэн	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч	7-р сарын 13	99279278
5	Д.Оюунтунгалаг	Эмчилгээ чанарын хяналтын улсын байцаагч	7-р сарын 14	99353784
6	Б.Солонго	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	7-р сарын 15	91113917

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 07 сарын 08 өдрийн А/Б
дугаар тушаалын хавсралт

9043446 2020030036

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨДРҮҮДЭЭР АЖИЛЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ**

№	Байгууллагын нэр	Ажиллах өдөр
Нэг. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ		
1	Өрхийн эрүүл мэндийн төвүүд	7 сарын 11,12,15-ний өдрүүдэд 10:00-14:00 цаг
2	Жаргалант сумын эрүүл мэндийн төв	Баяр наадмын бүх өдрүүдэд 24 цагаар ажиллана.
Хоёр. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ		
3	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Баяр наадмын бүх өдрүүдэд 24 цагаар ажиллана.
4	Бадархундага, Тайхар, Очир увидас хувийн хэвшлийн ортой эмнэлэг	
Гурав. Эмийн хангалт, хүртээмж		
5	Мөнхалтаргана, Энэрэхзаяа, Орхонсөд, Эко эмийн сан	Баяр наадмын бүх өдрүүдэд 24 цагаар ажиллана.
Дөрөв. Шүдний тусламж үйлчилгээ		
6	Натурмед шүдний эмнэлэг	7 сарын 10, 15-ний өдрүүдэд 10:00-16:00 цаг
7	Очир талст шүдний эмнэлэг	7-р сарын 10-аас 15-ний өдрүүдэд өдөр бүр 10:00-16:00 цагийн хооронд ажиллана.